



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 04

Ховд

**Хичээлийн шинэ жилийн нээлттэй холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. “б” дахь заалт, 29.1.5. “в”, Хог хаягдлын тухай хуулийн 9.3.10. заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

Дэлхий нийтээр тархаад буй Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр улс, орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласан энэ үед хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, эрсдэлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулахыг даалгаж байна.

Нэг.Сумдын Засаг дарга нарт:

1.1. Хичээлийн шинэ жилийн нээлтийг угтан төв суурин газруудын хог хаягдал, хогийн ургамлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулах

1.2. Цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж ажлын хэсэгт байгууллагын дарга, эрхлэгч, захирал, Багийн Засаг дарга, дүйцүүлэх албаны цэргүүдийг бүрэн хамруулах

1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн зураглал гаргаж холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хариуцуулан хуваарилах

1.4. Цэвэрлэгээний ажилд оролцож буй ажилтан, алба хаагчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах

1.5. Хог хаягдал, хогийн ургамлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж иргэд олон нийтийг орчноо цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаанд татан оролцуулах, уриалах

1.6. Цэвэрлэгээ болон ариутгал халдваргүйжүүлэлтийн тайланг нэгтгэн 2020 оны 08 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх

Хоёр.Байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт:

2.1. Харьяалах сумын Засаг даргын баталсан хуваарийн дагуу цэвэрлэгээний ажлыг чанартай хийж гүйцэтгэх

2.2. Байгууллагын эзэмшлийн болоод ойр орчмын 100м² талбайг цэвэрлэх

2.3. Цэвэрлэгээний ажлын тайланг 2020 оны 08 дугаар сарын 22-ны дотор сумын харьяа Засаг даргад хүргүүлж цахим хуудас болон телевизүүдээр сурталчилах

Гурав.Сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт:

3.1. Харьяалах сумын Засаг даргын баталсан хуваарь болон сургууль, цэцэрлэгийн эзэмшлийн талбайг цэвэрлэх

3.2. Сургууль, цэцэрлэгийн орчинд явган хүний гарц, сургууль, цэцэрлэгийн бүс гэсэн тэмдэг, тэмдэглэгээг хийх

3.3. Сургууль, цэцэрлэгийн ойролцоо үүссэн нүх, худаг, ил задгай цахилгааны утас зэргийг аюулгүй болгох

Дөрөв.Эрүүл мэндийн газрын дарга, Зоонозын өвчинтэй тэмцэх төвийн дарга нарт:


4.1. Ариутгал халдваргүйжүүлэлтийн талаар нэгдсэн төлөвлөгөө гарган үр дүнтэй зохион байгуулах

4.2.Ариутгал халдваргүйжүүлэлт хийхтэй холбогдуулан сум, байгууллагуудын ажлын хэсгийг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах

Тав. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдуулан нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийг 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулж хэвших, цэвэрлэгээ хийх байгууллага, аж ахуйн нэгжийн хуваарь гарган хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Зургаа. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ